



ЭЗЭНГЭЙ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

74

**Байгалийн ургамлын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

79

**Түлш, эрчим хүчний салбарын
талаар авах зарим арга
хэмжээний тухай**

Монгол Улсын
өнхийлөгчийн
зарлиг

83

**Прокурорын ёс зүйн дүрэм
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|---|----|
| 4. | Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 74 |
| 5. | Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 77 |
| 6. | Зээлийн хэлэлцэр соёрхон батлах тухай | 79 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|----|--|-----------|----|
| 7. | Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 72 | 79 |
| 8. | Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай | Дугаар 73 | 81 |
| 9. | Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай | Дугаар 75 | 83 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|---------------------------------------|------------|----|
| 10. | Прокурорын ёс зүйн дүрэм батлах тухай | Дугаар 268 | 83 |
|-----|---------------------------------------|------------|----|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|----|
| 11. | Журам шигэчлэн батлах тухай | Дугаар 254 | 90 |
| 12. | "Эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 268 | 96 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2¹ дүгээр зүйл:

"2¹ дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "байгалийн ургамал" гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг;

2/ "байгалийн ургамлын нөөц" гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг;

3/ "байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа" гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг;

4/ "байгалийн ургамлыг тарималжуулах" гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор тарьж ургуулах, үржүүлэх ажиллагааг;

5/ "ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ" гэж тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж жингийн мөнгөн үнэлгээг;

6/ "харь ургамал" гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар лөөрөөлөгдөн ирж, чутлаггүй байдлаар зүйл ургамлыг;



2/7 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"6.Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно.

7.Харь ургамлыг байгальд тарималжуулахад зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн талбайг ашиглана."

3/7¹ дүгээр зүйл:

"7¹ дүгээр зүйл.Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох

1.Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

2.Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3.Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх зардлыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж болох ургамлын төрөл, зүйлийн нэр, түүх дээд хязгаарыг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно."

4/13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна."

5/17 дугаар зүйлийн 3-5 дахь хэсэг:

"3.Ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцууг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг хориглоно.

4.Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно.



5.Судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг Засгийн газар тогтооно.”

6/21 дүгээр зүйлийн 5 дахь заалт:

“5.Хууль тогтоомж зөрчиж байгалийн ургамал бэлтгэх зөвшөөрөл олгосон, эсхүл ургамал, түүний гаралтай түүхий эдийг гадаадад гаргах зөвшөөрөл олгосон албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

7/21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3.Ургамлын нөхөн төлбөрийн хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтооно.

4.Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага батална.”

2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэсний дараа “аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн” гэж, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хадлан авахыг” гэсний дараа, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж, байгууллагад” гэсний дараа “мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн” гэж, 21 дүгээр зүйлийн “Шүүгч, байгаль орчны байцаагч” гэсний өмнө “1.” гэж, мөн зүйлийн 1 дэх заалтын “хэмжээг хэтрүүлэн түүж бэлтгэсэн” гэсний дараа “, ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулсан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйл:

“2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж

1.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд таснид эсрээр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.”

2/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно."

3/17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгалийн ургамлыг аливаа зориулалтаар түүж бэлтгэхийг хориглоно."

4 дүгээр зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "шинжилгээний" гэснийг "шинжилгээ, ахуйн" гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "51, 52" гэснийг "52, 53" гэж, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "500-5000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "50000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн хэсгийн 2 дахь заалтын "5000-15000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "50000-75000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын "10000-20000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "75000-100000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж, мөн хэсгийн 4 дэх заалтын "10000-25000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний" гэж, "100000-150000" гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйл:

“5 дугаар зүйл.Төлбөр тооцох үзүүлэлт

Ургамал ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.”

2/6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

*1.Ургамал ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	доод	дээд
1.Нэн ховор	25	30
2.Ховор	15	20
3.Элбэг	5	10

3/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“1/төлбөрийн данс, баримтыг будлиантуулсан, ургамал ашигласны төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

2 дугаар зүйл.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бэлнээр сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтанд, эсхүл бэлэн бусаар сум, дүүргийн төсөвт тус тус” гэснийг “сум, дүүргийн төсөвт” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бэлнээр хураасан төлбөрийг тухай бүр сум, дүүргийн төсөвт оруулна” гэснийг “төлбөрийг бэлнээр хураан авахыг хориглоно” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтын “бэлэн болон бэлэн бусаар төсөвт оруулсан” гэснийг “ургамал ашигласны” гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын “Улсын татварын ерөнхий газарт” гэснийг “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, мөн хэсгийн 4 дэх заалт, 5 дахь хэсгийн “Улсын татварын ерөнхий газар” гэснийг “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.



3 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан Байгальын ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт, зээлийн банк хооронд 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**Түлш, эрчим хүчний салбарын талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Улсын Их Хурлын даргын 2009 оны 204 дүгээр захирамжаар байгуулагдсан Түлш, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Түлш, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т



даалгасугай.

1/Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай болон эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын урт хугацаат зээлийг анх зээлсэн үеийн ханшаар тооцон төгрөгт шилжүүлэх, ханшийн зөрүүнээс үүсэх алдагдлыг Засгийн газар бүрэн хариуцаж тухайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох, цаашид мөнхүү урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулах асуудлыг судлах;

2/төвийн бүсийн эрчим хүчний компаниудад улсын төсвөөс олгож байгаа татаасын хэмжээгээр тухайн салбарын компаниуд болон нүүрсний уурхай хоорондын хуучин өр, авлагыг бүрэн хаах;

3/хэрэглэгчид ирэх ачааллыг хөнгөлөх зорилгоор 3 жилийн хугацаанд Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай болон төрийн өмчийн эрчим хүчний компаниудад улсын төсвөөс олгож байгаа татаасыг бууруулахгүй байх, тарифын орлогоор санхүүжүүлэх боломжгүй өндөр өртөг бүхий томоохон шинэчлэлийн ажлуудыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

4/эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг эрчимжүүлэн менежментийг сайжруулж, үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, нүүрс боловсруулж ашиглах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

5/аймгуудын төв, түүний дотор тэргүүн ээлжинд Ховд, Увс, Дорноговь, Сэлэнгэ аймаг болон Хөтөл тосгоны дулааны станц, дулааны шугам сүлжээний үйл ажиллагааг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх, эсхүл Концессын тухай хуульд заасны дагуу хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах хувилбаруудыг судлан аль оновчтойг нь сонгох замаар техник, технологийн шинэчлэл хийх, боловсон хүчин, цалин хөлс, үнэ тарифын нэгдсэн бодлогоор хангах асуудлыг шийдвэрлэх;

6/эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өртөг, зардлыг хямдруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор эрчим хүчний шинэ эх үүсвэрийг Багануур болон бусад нүүрсний уурхайг түшиглэн барьж байгуулах, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа цахилгаан, дулааны хэрэгцээг 3, 4 дүгээр цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөн шинэчлэх замаар шийдвэрлэх;

7/улсын төсвөөс татаас олгож байгаа хугацаанд ахуйн



цахилгааны үнэ, тарифыг шатлалтай болгон өрх бүрийн сарын хэрэглээний 150 кВтц-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх;

8/эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, 26.2.5-д заасны дагуу зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх;

9/Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан түгээх сүлжээг бүрэн шинэчилж, өвлийн улиралд шөнийн цагаар ахуйн цахилгааны хэрэглээний үнэ, тарифыг "0" төгрөгт шилжүүлэх талаар бодлого боловсруулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцын талаар жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1."Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



Монгол Улсын Их Хурлын 2010 оны
73 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД
ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

1. Баянхонгор аймаг

/мян.төг/

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Баянхонгор	Спорт цогцолборын барилга /спорт заал, контор, уурын зуух/	900,000.2
2	Баянхонгор	Улаанбулан	252,861.7
3	Баянхонгор	Аж ахуйн склад	2,505.7
4	Баянхонгор	Дизелийн байр-мужаан цех	68,335.9
5	Баянхонгор	Манагчийн байр	376.1
6	Баянхонгор	Уурын зуух /2 тогоотой/	5,931.2
	ДҮН		1,230,010.8

2. Увс аймаг

/мян.төг/

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Улаангом	Нийгмийн даатгалын хэлтсийн конторын хуучин барилга	32,500.0
	ДҮН		32,500.0
	НИЙТ ДҮН		1,262,510.8

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2010 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот**Зарим Байнгын хорооны
даргыг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дагвадоржийн Очирбат, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдингийн Хаянхярваа, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Доржийн Одбаяр нарыг тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2010 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 268

Улаанбаатар
хот**Прокурорын ёс зүйн дүрэм
батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 42¹ дугаар зүйлийн 42^{1.5} дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ нь:**

1. Прокурорын ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Энэ зарлиг батлагдсантай холбогдуулам Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт, 2007 оны 283 дугаар зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ**



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны
12 дугаар сарын 27-ны өдрийн 268 дугаар
зарлигийн хавсралт**

ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж хамгаалах зарчим, хэм хэмжээ, хуульд нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий прокурорын шийдвэрийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгаж чиг үүргээ чин шударгаар хэрэгжүүлэх гол нөхцөл мөн.

Прокурор ёс зүйн зөрчил гаргах нь иргэд, олон нийт, иргэний нийгмийн зүгээс прокурорт итгэх итгэлийг алдагдуулах, прокурорын байгууллагын нэр хүндийг бууруулах сөрөг үр дагавартай тул прокурор бүр ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдвөл зохино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт

1.1. Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт нь Прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйг тогтоон хэвшүүлэх, прокурорын нэр төрийг хамгаалахад оршино.

2 дугаар зүйл. Прокурорын ёс зүйн хэм хэмжээ

2.1. Прокурор нь төрийн тусгай албан хаагч, өвөрмөц чиг үүрэг бүхий албан тушаалтан болохын хувьд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг прокурорын ёс зүйн хэм хэмжээ гэнэ.

2.2. Прокурорын ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.2.1. Хүний эрх, эрх чөлөөг тууштай хангуулах

2.2.2. Хуулийг хүндэтгэн дээдэлж, чанд сахин биелүүлэх

2.2.3. Прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх



2.2.4. Прокурор гадны нөлөөнд үл автах

2.2.5. Хуулийг нэг мөр хэрэглэх

2.2.6. Прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгах, өөрийн ажил, албан тушаалдаа хүндэтгэлтэй хандах

Хоёр. Прокурорын ёс зүйн тусгайлсан хэм хэмжээ

3 дугаар зүйл. Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад баримтлах ёс зүйн хэм хэмжээ

3.1. Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч, түүний өмгөөлөгчтэй харилцахдаа ямарваа ялгавартай байдал гаргахгүйгээр тэдэнд хүндэтгэлтэй хандаж тухайн хэргийг шударга, зөв шийдвэрлүүлэх итгэл үнэмшлийг төрүүлж чадахуйц мэдлэг, харьцааны соёлтой байна.

3.2. Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид болон бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа аашилж зандрах, айлган сүрдүүлэх, догшин хэрцгий хандах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргахгүй байна.

3.3. Прокурор нь хувийн сонирхлын үүднээс харьяаллын бус, бусдын хяналтанд байгаа хэрэг, материалтай танилцах, зөвлөгөө өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шяажээч нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавихыг цээрлэж, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлэхгүй байна.

3.4. Прокурор нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг, материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэрэг, материалын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэхгүй байна.

3.5. Прокурорт хандаж гаргасан байгууллага, иргэдийн хүсэлт, гомдол, мэдээлэлд анхааралтай хандаж, хуульд заасан хугацаанд шийдвэрлэж байна.

3.6. Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн болон ойр дотно харилцаатай хүмүүс, өмнө нь ажиллаж байсан, эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэн, захиргааны хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд

оролцохгүй.

3.7. Прокурор хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч, сэжигтэн, яллагдагчийг яллах, цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг адил тэнцүү тогтоолгох үүргийг хангаж, хэт нэг талыг барьж асуудалд хандахгүй байх.

3.8. Прокурор гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотолж байх, хэрэв гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлийг нотолж чадахгүйд хүрвэл хариуцлага хүлээдэг байх.

3.9. Хүнд суртал гаргах, хэргийг шалгаж хянах нөрийн дор байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг тодорхой зорилгогүйгээр хэргийг нь шийдвэрлэхгүй удаашруулах, тэдгээрээс гаргасан хууль ёсны, үндэслэлтэй гомдол, хүсэлтийг хүлээн авч хангахгүй байх зэргээр эрхийг нь зөрчж чирэгдүүлэхгүй байх.

3.10. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргийг аль нэг талд нь ашигтай шийдвэрлэх талаар бусдад урьдчилан амлалт өгөхгүй байх.

3.11. Өөрийн хяналтанд байгаа хэргийн талаар бусдад ярих, мэдээлэхгүй байх.

3.12. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй мөрдөх.

3.13. Хэрэг, материал хянах явцдаа олж мэдсэн хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой асуудлыг бусдад задруулахгүй байх.

4 дүгээр зүйл. Хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ

4.1. Прокурор дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

4.1.1. Прокурорын хяналтын чиг үүрэгтэй холбогдолгүй асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох;

4.1.2. Багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхдээ тэдгээр байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох;

4.1.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр прокурорын



байгууллагын нэр хүндэд харш сурталчилгаа хийх.

4.2. Прокурор нийгэм, соёлын арга хэмжээнд оролцохдоо уг үйл ажиллагаа, арга хэмжээ нь прокурорын байгууллагын нэр хүндэд харшлахаар бол түүнээс татгалзана.

4.3. Албан үүргээ хэрэгжүүлэхэд харшлах, эсхүл сөргөөр нөлөөлөх, прокурорын албан тушаалыг ямар нэг байдлаар ашиглахыг санаархсан аливаа хэлцэл, үйл ажиллагаанаас зайлсхийнэ.

4.4. Прокурорын албан тушаалд харшлах үндэслэл бүхий хөрөнгө оруулалт, бизнесийн бусад ашиг сонирхлоос татгалзана.

4.5. Албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан аливаа мэдээллийг өөрийн санхүүгийн эх үүсвэр болгон ашиглахгүй.

4.6. Прокурор нь Авлигын эсрэг хуулийн зөвшөөрөгдсөн хүрээнд бэлэг авч болох боловч эрхэлж буй ажил, албан тушаалтайгаа холбоотойгоор бусдаас хандив, тусламж, зээл хүсэх, шан харамж, бэлэг авах, ямар нэг байдлаар хувьдаа давуу байдал олж авах, мөн түүнчлэн түүхт ой, баяр ёслолыг тохиолдуулан аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс бэлэг сэлт, үнэ бүхий зүйл авахыг хориглоно.

4.7. Хэргийн оролцогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүн болон өмгөөлөгчтэй хувийн харьцаа тогтоож, тэднээр дайлуулах, үйлчлүүлэх, ажил гүйцэтгүүлэхгүй байх.

4.8. Прокурор багшлах болон эрдэм ивэнжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

5 дугаар зүйл. Прокурорын улс төрийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт

5.1. Прокурор улс төрийн дараах үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

5.1.1. Бүх шатны улс төрийн сонгуулийг зохион байгуулах байгууллагын бүрэлдэхүүнд орох;

5.1.2. Улс төрийн аливаа байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаал эрхлэх;

5.1.3. Улс төрийн сонгуульд нэр дэвшигчид болон улс



төрийн намд хөрөнгө мөнгө олж өгөхөөр амлах, зуучлах, хандив өргөх, бусад тусалцаа үзүүлэх;

5.1.4. Улс төрийн байгууллага, нэр дэвшигчийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох.

6 дугаар зүйл. Прокурор биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ

6.1. Прокурор нь өөрийн бүхий л үйл ажиллагаа, биеэ авч явах байдлаараа прокурорын байгууллагын нэр хүндийг хамгаалж, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж байна.

6.2. Албан үүргээ хэрэгжүүлэх болон эрх бүхий байгууллагаас шаардсанаас өөр тохиолдолд бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар тодорхойлохгүй.

6.3. Эрдэм шинжилгээний ажил эрхлэх, багшлах, зохиол бүтээл туурвах, хэвлэн нийтлэх, гэрээ хэлцэл байгуулахад прокурорын албан тушаал, прокурорын байгууллагын нэр хүндийг ашиглахаас зайлсхийнэ.

6.4. Дүрэмт хувцастай яваа үедээ, түүнчлэн албан үүрэг гүйцэтгэж явах үедээ буюу ажлын байранд, эсхүл байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчтэй ууж согтуурах, мансуурахыг хориглоно.

6.5. Прокурор ууж согтууран эрүүлжигдэх, захиргааны арга хэмжээ авагдах, бусадтай зүй бусаар харьцах, бусдыг доромжлохыг цээрлэнэ.

7 дугаар зүйл. Прокурор хөрөнгө орлогоо мэдүүлэх

7.1. Прокурорын хууль тогтоомжид заасны дагуу өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлогыг үнэн зөвөөр мэдүүлж байх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Прокурор эрх ашгаа хамгаалуулах эрхтэй

8.1. Хэрэв прокурорын талаар үндэслэлгүй нийтлэл хэвлүүлсэн, нэвтрүүлсэн тохиолдолд тухайн прокурор, эсвэл түүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага шүүхэд хандиж, прокурорын нэр хүндийг сэргээлгэх, эд хөрөнгийн бус гэм хорын хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй.



Гурав. Прокурорын ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх

9 дүгээр зүйл. Прокурорын ёс зүйн зөрчил

9.1. Прокурорын ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон прокурорын ёс зүйн хэм хэмжээг санаатай буюу санамсаргүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

10 дугаар зүйл. Прокурор ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг хүлээн авах, түүнийг хянан шийдвэрлэх

10.1. Прокурор ёс зүй зөрчсөн тухай гомдлыг дараах үндэслэлээр шалгаж шийдвэрлэнэ:

10.1.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шинжээч, өмгөөлөгч, шүүгч хүсэлт гаргасан;

10.1.2. Иргэн, албан тушаалтан, байгууллага гомдол, мэдээлэл ирүүлсэн;

10.1.3. Эрүүгийн болон иргэн, захиргааны хэргийн оролцогчид, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийн гомдол, хүсэлт.

10.2. Прокурор ёс зүйн зөрчил гаргасан тухай асуудлыг Прокурорын ёс зүйн зөвлөл шалгана.

11 дүгээр зүйл. Ёс зүйн дүрмийг биелүүлээгүйгээс гарах үр дагавар

11.1. Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдвол тухайн прокурорт Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

11.2. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулахдаа энэ дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг урьдчилан заавал шалгаж тогтоосон байна.

12 дугаар зүйл. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа

12.1. Ёс зүйн зөрчлийг "Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-д зааснаар хянан шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 254

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ой хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ

Засгийн газрын 2010 оны 254 дүгээр
тогтоолын хавсралт

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УЧИРСАН ХОХИРЛЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 23.3-т заасан ой, хээрийн түймрийн улмаас учирсан хохирлыг тооцож, тодорхойлоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. "түймрээс учирсан хохирол" гэж ой, хээрийн түймрийн нөлөөгөөр учирсан экологи, эд материалын хохирол, түймэр унтраахад гарсан шууд болон шууд бус зардлыг;

1.2.2. "экологийн хохирол" гэж түймрийн нөлөөгөөр байгалийн экологийн тогтолцооны хэвийн байдал, ойн хөрс, ус хамгаалах



чадвар алдагдах, амьтан, ургамал устгах болон тэдгээрийн төрөл, зүйлийн амьдрах орчин доройтох, байгалийн нөөц баялаг хомсдохыг;

1.2.3. "эд материалын хохирол" гэж түймрийн нөлөөгөөр барилга байгууламж, гэрийн тэжээмэл амьтан, мал, таримал ургамал, өвс тэжээл, малын хашаа, сараач, машин, техник тоног төхөөрөмж, гэр, орон сууц, эд материал зэрэг үндсэн болон эргэлтийн хөрөнгө гэмтэх, устгах зэргээр улс, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирсан шууд хохирлыг;

1.2.4. "ой, хээрийн түймрээс учирсан хохирлын акт" гэж эрх бүхий байгууллагаас томилогдсон ажлын хэсэг түймэрт нэрвэгдсэн талбайд судалгаа хийж, түймрээс учирсан хохирлыг тодорхойлж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсан баримт бичгийг;

1.2.5. "ой модны шаталтын зэрэглэл" гэж түймрийн төрөл, шаталтын эрчим, хэлбэр зэргээс хамаарч ойн мод, ургамал, хөрсний гэмтсэн хэмжээг;

1.3. Ой, хээрийн түймрийн хохирлыг тооцож тодорхойлох ажлыг Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу зохих шатны Засаг даргын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг гүйцэтгэнэ.

1.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь 5-аас доошгүй гишүүнтэй байна. Ажлын хэсэгт хууль хяналтын, онцгой байдлын, байгаль орчны байгууллага болон ойн мэргэжлийн хүмүүсийг оролцуулна.

1.5. Ажлын хэсэг нь ой модны шаталтын зэрэглэлийг тогтоож, ой, хээрийн түймрээс учирсан хохирлын акт үйлдэх бөгөөд энэ нь түймэр тавьсан, санамсаргүй алдсан буруутай этгээдтэй эрх бүхий байгууллагаас хариуцлага тооцох, түүнээс нөхөн төлбөр гаргуулах үндсэн баримт болно.

1.6. Энэхүү журмыг зөрчсөн ажлын хэсгийн гишүүнд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хоёр. Ой, хээрийн түймэрт нэрвэгдсэн талбайд судалгаа явуулах

2.1. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тодорхойлох зорилгоор шатсан талбайг судлах ажил нь бэлтгэл ажил болон хээрийн судалгаа гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.



2.2. Бэлтгэл ажил нь дараахь ажилбараас бүрдэнэ:

2.2.1. тухайн бүс нутгийн байр зүйн болон бусад холбогдох газрын зургийг бэлтгэж, түймэр гарсан газрыг тоймлон тэмдэглэх;

2.2.2. түймрийн хохирлыг тодорхойлоход шаардагдах ой, хадлан, бэлчээр, ан амьтан зэрэг байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний материалыг бүрдүүлж, нарийвчлан судлах;

2.2.3. түймэрт нэрвэгдсэн газар байрлаж байсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эд материалын хохирлын талаар мэдээлэл цуглуулах;

2.2.4. түймэртэй тэмцэхэд гарсан зардалтай холбоотой материалыг бүрдүүлэх;

2.2.5. түймэрт нэрвэгдсэн талбайд үзлэг явуулахад шаардагдах тээврийн хэрэгсэл, уналга, багаж хэрэгсэл, ажлын хувцсыг бэлтгэх.

2.3. Энэхүү журмын 2.2-т заасан бэлтгэл ажлыг хангасны дараа түймэрт нэрвэгдсэн талбайн хээрийн судалгаа хийнэ.

2.4. Талбайн судалгаа нь тойм болон жишиг судалгаа гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

2.5. Тойм судалгааг түймэрт нэрвэгдсэн нийт газрыг хамруулан хийнэ. Энэ судалгаагаар тухайн түймрийн төрөл, хэлбэр, эрчим, тархалтын хэмжээг тоймлон тогтоож, байр зүйн зурагт тэмдэглэн, түймэрт нэрвэгдсэн эд хөрөнгийн хэмжээ, түймэрт шатсан байдлыг тогтоож, түймрийн шаталтын зэрэглэлийг нарийвчлан тогтоох зорилгоор жишиг талбай байгуулах газрыг сонгоно.

2.6. Нэг жишиг талбай нь 20x20 м (400 м²)- 30x30 м (900м²) хэмжээтэй байна. Жишиг талбайн нийлбэр хэмжээ нь тойм судалгаа хийсэн түймэрт нэрвэгдсэн талбайн 1-ээс доошгүй хувийг хамарсан байна.

2.7. Жишиг талбайг тухайн нутаг дэвсгэрийн түймэрт нэрвэгдсэн байдлыг төлөөлөн илэрхийлж чадахаар хэсэгт, янз бүрийн эрчимтэй шатсан газарт байгуулна.

Гурав. Ой модны шаталтын зэрэглэл тогтоох

3.1. Ой модны шаталтын зэрэглэлийг зөв тогтоож түймрээс учирсан



хохирлыг янз бүрийн эрчимтэй шатсан ойн талбай бүрээр нарийвчлан тооцон тодорхойлсноор, сөрөг үр дагаврыг арилгах, шатсан ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2. Ойн түймэрт нэрвэгдсэн байдлыг харгалзан тухайн ой модны шаталтын зэрэглэлийг сул, дунд, хүчтэй, нэн хүчтэй гэж ангилна. Шаталтын зэрэглэл ойн түймрийн эрчмээс хамаарна. Сул эрчимтэй түймэрт нэрвэгдсэн ой модны шаталтын зэрэг бага, дунд, өндөр, нэн эрчимтэй түймрийн үед ой модны шаталтын зэрэг их байна.

3.3. Янз бүрийн эрчимтэй шатсан ойд жишиг талбай байгуулан мод, есвэр модны тооллого, хэмжилт хийж, амьд болон үхсэн модны тоо, нөөц, ургаа модны гэмтлийн шинж байдлыг тогтооно. Үүний зэрэгцээ ургамлын нөмрөг, хөрсний шатсан байдалд үнэлгээ өгч ой модны шаталтын зэрэглэлийг тогтооно.

3.4. Түймэрт нэрвэгдсэн ой модны нөөцийн 15 хүртэл хувь нь цаашид ургах боломжгүй болсон тохиолдолд шаталтын сул зэрэглэлд, модны нөөцийн 16-45 хүртэл хувь шатсан бол дунд зэрэглэлд, 46-75 хүртэл хувь шатсан бол хүчтэй зэрэглэлд, 76-гаас дээш хувь шатсан нөхцөлд шаталтын нэн хүчтэй зэрэглэлд тус тус хамааруулна.

3.5. Ойн түймрийн шаталтын зэрэглэлийг тооцсон хүснэгт, материалыг түймрээс учирсан хохирлын актад хавсаргана.

Дөрөв. Экологийн хохирлыг тодорхойлох

4.1. Тухайн талбай дахь байгалийн нөөц баялаг, ойн шаталтын зэрэглэлтэй уялдуулан экологийн хохирлыг мөнгөн үнэлгээгээр илэрхийлнэ.

4.2. Экологийн хохирлыг тооцохдоо тухайн баялгийн нэгж талбайн экологи-эдийн засгийн үнэлгээг үндэс болгоно.

4.3. Шаталтын сул зэрэглэлд хамаарах ойн 1 га тутмын хохирлыг ойн экологи-эдийн засгийн үнэлгээний 5 хувиар, шаталтын дунд зэрэглэлд хамаарах ойн 1 га тутмын хохирлыг ойн экологи-эдийн засгийн үнэлгээний 10 хувиар, шаталтын хүчтэй зэрэглэлд хамаарах ойн 1 га тутмын хохирлыг уг үнэлгээний 20 хувиар, нэн хүчтэй зэрэглэлд хамаарах ойн 1 га тутмын хохирлыг уг үнэлгээний 30 хувиар тооцно.

4.4. Тухайн төрлийн модны 1 га ойн талбайд тооцсон экологийн хохирлыг шатсан нийт талбайд шилжүүлж түймрээс учирсан хохирлыг тодорхойлно.

4.5. Түймэрт нэрвэгдсэн талбай дахь модны төрөл бүрээр тооцсон хохирлын нийлбэрээр нийт учирсан хохирлыг тогтооно.

4.6. Ашиглалтын нас гүйцээгүй ойд учирсан хохирлыг ойн экологи-эдийн засгийн болон модны нөөцийн эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан ой модны насны ангийн дараахь итгэлцүүрээр бууруулж тооцно:

Ой модны насны ангийн итгэлцүүр

Насны ангилал	Ойн төрөл	
	Шилмүүст	Навчит
1 дүгээр	0.24	0.35
2 дугаар	0.31	0.48
3 дугаар	0.45	0.91
4 дүгээр	0.67	0.95
5 болон түүнээс дээш	1.0	1.0

4.7. Түймэрт нэрвэгдсэн бэлчээрийн хохирлыг намрын улиралд суурь үнэлгээг 0.03, хаврын улиралд 0.01 итгэлцүүрээр үржүүлж тооцно.

Тав. Эд хөрөнгийн хохирлыг тодорхойлох

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эд хөрөнгийн хохирлыг дараахь байдлаар тодорхойлно:

5.1.1. барилга байгууламж, машин, техник тоног төхөөрөмж бусад эд хөрөнгийн хохирлыг тайлан тэнцлийн үнээр, ийм үнэгүй бол тэдгээрийг ашиглаж эхлэх үеийн зах зээлийн үнийг үндэслэн шатсан байдал, элэгдэл, хорогдлын шимтгэлийг харгалзан;

5.1.2. шатсан орон сууц гэр, малын хашаа, саравчны хохирлыг тухайн үеийн зах зээлийн үнэ, ашиглалтын хугацааг харгалзан;

5.1.3. бэлтгэсэн мод, өвс, хүнсний ногоо, мал, гэрийн тэжээмэл амьтан, байгууллага, иргэдийн эд хөрөнгийн хохирлыг тухайн үеийн зах зээлийн үнээр.

5.2. Түймэрт шатсан таримал ургамал, үр тарианы хохирлыг тухайн жилд нэг га-гаас авахаар тогтоосон ургацын хэмжээг, хэрэв ургацын хэмжээг тухайн жилд тогтоогоогүй бол сүүлийн 3 жилд авсан нэг га-гийн дундаж ургацын хэмжээг тухайн үеийн таримал ургамал, үр тарианы зах зээлийн үнийг тус тус үндэслэн тооцно.

5.3. Ойн санд шилжээгүй таримал ойд учирсан хохирлыг 1 га талбайд уг ойг тарьж ургуулахад зарцуулсан тухайн үеийн зардлаар тооцно.

5.4. Мод үржүүлгийн байнгын болон түр талбай, хүлэмжид үржүүлж байгаа бөгөөд жишгийн хэмжээнд хүрээгүй тарьц, суулгацын хохирлыг үр бэлтгэх, хөрс боловсруулах, тэдгээрийг ургуулахад усалж, арчилж, хамгаалсан ажлын бодит зардлаар, мод үржүүлгийн газарт хөшилт, хамгаалалт хийсэн, барилга байгууламж болон жишгийн хэмжээнд хүрсэн тарьц, суулгацын хохирлыг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцно.

Зургаа. Зардлыг тооцох

6.1. Ой, хээрийн түймэртэй тэмцэхэд гарсан зардлыг санхүүгийн үндсэн баримтыг үндэслэн шууд болон шууд бус гэсэн хэлбэрээр тооцно.

6.2. Шууд зардалд түймэртэй тэмцэхэд дайчлагдан ажилласан машин, техникт хэрэглэсэн бензин, шатахуун, хүмүүсийн хоол, хүнсний үнэ бусад зардал багтана.

6.3. Шууд бус зардалд түймэрт дайчлагдан ажилласан хүмүүсийн цалин, томилолтын зардал, нисэх онгоц, нисдэг тэрэг, бусад тээврийн хэрэгсэл ашигласны хөлс, холбооны хэрэгслээр ярьсан зардал, түймэртэй тэмцэхэд зориулан тусламжаар ирүүлсэн техник хэрэгслийн тээврийн зардал, гаалийн татвар, түймэрт нэрвэгдсэн талбайд үзлэг явуулахад шаардагдах тээврийн хэрэгсэл, уналга, багаж хэрэгсэл, ажлын хувцасны зардал, машин, техник ашигласны хөлс тус тус багтана.

Долоо. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлын акт тогтоох

7.1. Экологийн болон эд хөрөнгийн хохирол, түймэртэй тэмцэхэд гарсан зардлыг үндэслэн түймрээс учирсан хохирлын актыг тогтооно. Түймрээс учирсан хохирлын актад ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж зохих шатны Засаг даргаар баталгаажуулна. Актад холбогдох тооцоо, баримт, зураг зэргийг хавсаргана.

7.2. Түймрээс учирсан хохирлын актын маягтыг байгаль орчны

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.3. Актыг 4 хувь үйлдэж гэм буруутай этгээдээр гарын үсэг зуруулан /ийм этгээд тогтоогдоогүй бол гарын үсэггүйгээр/ зохих шатны Засаг даргын Тамгын газар, хуулийн байгууллага, онцгой байдлын болон ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус бүрт нэг хувийг хүргүүлнэ.

7.4. Шаардлагатай гэж үзвэл зохих шатны Засаг даргын Тамгын газар тогтоосон актад мэргэжлийн байгууллагаар магадлан шинжилгээ хийлгэж болно.

7.5. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлын актыг Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд заасан хугацаанд багтаан гаргаж энэхүү журмын 7.3-т заасан байгууллагад хүргүүлнэ.

7.6. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлын акттай холбогдон талуудын хооронд үүссэн маргааныг тухайн шатны Засаг дарга материалыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг талууд эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 268

Улаанбаатар
хот

“Эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран Сөвлөлийг Эрүүл мэндийн сайд С.Лямбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашнүлүүн нарт тус тус даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөв, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хандивлагч байгууллагын хөтөлбөр, төсөлд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, дунд хугацааны үнэлгээний тайланг 2015 онд, эцсийн үнэлгээний тайланг 2021 онд багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2010 оны 268 дугаар
тогтоолын хавсралт

**“ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2010-2021 ОН)**

Нэг, Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт “Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж 2015 он гэхэд Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна” гэж заасан.

2001 онд Улсын Их Хурлаар баталсан Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого нь эрүүл мэндийн салбарт хийсэн өөрчлөлт, шинэчлэлтийн үйл ажиллагааны үзэл баримтлал болж ирсэн. Энэхүү бодлогын баримт бичигт тулгуурлан Засгийн газраас эрүүл мэндийн салбарт Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр /2002/, Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр /2002/, Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /2002/, Эрүүл мэндийн технологийг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002/, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр /2001/ зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн байна. Одоогоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний III хөтөлбөр /2007/, Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2002/, Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2002/, Халдварт бус өвчнөөс



сэргийлэх, хянах хөтөлбөр /2005/, "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөр /2006/, Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /2005/, "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр /2006/, Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр /2007/, Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө /2005/, Иод дутлын эмгэгтэй тэмцэх III хөтөлбөр /2007/, "Хүнсний баталгаат байдал" үндэсний хөтөлбөр /2001/, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002/, Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр /2003/, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр /2005/, Цахим Монгол үндэсний хөтөлбөр /2005/ зэрэг бодлогын баримт бичгүүдийг тус тус батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, зөрчлийг арилгах болон хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийж байна.

Дээр дурдсан хөтөлбөр, төлөвлөгөө нь эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг иж бүрнээр нь цогц шөвжтэй хамарч чадахгүй байна. Иймд эдгээр хөтөлбөрийг өөртөө дэд хөтөлбөр шинжтэйгээр багтаасан, эрүүл мэндийн салбарын урт хугацааны стратегийн зорилтыг тодорхойлсон "Эрүүл мэнд хөтөлбөр"-ийг /цаашид "хөтөлбөр" гэнэ/ батлан гаргах шаардлагатай болсон юм.

Хөтөлбөр нь эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог хангах, давхардлыг арилгах, нэгтгэх, салбарын урт хугацааны суурь баримт бичиг юм. Хөтөлбөрийг эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулсан болно. Хөтөлбөрт стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндсэн 5 чиглэлийн дагуу боловсруулсан бөгөөд нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийн боловсрол, ялангуяа гэр бүлийн түвшинд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх асуудалд тэргүүлэх ач холбогдлыг өгсөн болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын хүн амын эрүүл мэндийг сайжруулж өсөлтийг дэмжих, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон улсын жишигт дүйцүүлэн хүргэх, хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэрэгжүүлэхээр эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино.

Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

-нотолгоонд тулгуурласан шинэ техник, технологи нэвтрүүлсэн байх;

-жендэрийн мэдрэмжтэй байх;

-төрийн зохицуулалттай, салбарын онцлог бүхий зах зээлийн чиг баримжаатай байх;

-төрийн болон хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон нийтийн санаачилга, оролцоонд тулгуурласан байх.

Дөрөв. Хөтөлбөрийн стратегийн зорилтууд

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь стратегийн зорилтыг удирдлага болгоно:

Стратегийн зорилт 1. Хүн амын өвчлөлд нөлөөлөх эрсдэлт зан үйлийг өөрчлөх;

Стратегийн зорилт 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх;

Стратегийн зорилт 3. Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах;

Стратегийн зорилт 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлж, байгууллагын хөгжил, салбарын удирдлагын тогтолцоог цогцоор нь хөгжүүлэх;

Стратегийн зорилт 5. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, төсвийн санхүүжилтийн хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх.

Тав. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Стратегийн зорилт 1-ийн хүрээнд:



1. Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, улмаар зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгаа /МСС/-г чанаржуулах талаар:

-эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор бүх шатны боловсролын байгууллагын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр, арга зүйн стандартыг боловсронгуй болгох;

-дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүдэн гарах өвчин, эмгэгээс эрүүл мэндээ хамгаалах, өвдсөний дараа бус өөдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.

2. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн бэхжүүлэх талаар:

-эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх тогтолцоог боловсронгуй болгох арга, хэлбэрийг тодорхойлж мөрдөх;

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог эрүүл мэндийн бүх байгууллагад бий болгох, хариуцлагыг сайжруулах;

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа ажилтны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд харилцааны соёлыг оруулах;

-төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараахь сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийг дэмжих, эрсдэлт зан үйлийг өөрчлөх МСС, ёс зүй, харилцаа, зөвлөгөө өгөх ур чадварын хичээл оруулах.

3. Олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох талаар:

-эрүүл орчин бий болгоход хамт олны оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

-эрүүл хот, дүүрэг, сүм, баг, ажлын байр, сургууль хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах;



-эрүүл орчин, түүний ач холбогдлын талаархи ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудыг үе шаттайгаар хамруулах;

-амьдралын зөв зохистой хэвшил, бие бялдраа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Хүлээгдэж байгаа үр дүн:

-үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийн байгууллагын тоо нэмэгдэнэ;

-үйлчилгээ үзүүлж байгаа ажилтны ёс зүй, харилцааны ур чадвар дээшилнэ;

-эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо нэмэгдэнэ;

-орчны эрүүл мэндийг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагаанд хамт олны оролцоо, салбар дундын хамтын ажиллагаа дээшилнэ;

-хүн амын дунд эрүүл амьдрах орчноо өөрөө бүрдүүлэх, төлөвшүүлэх хэвшил тогтоно.

Стратегийн зорилт 2-ын хүрээнд:

1. Хүн ам, ялангуяа эх, хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүст хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар:

-“Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

-эмнэлэг хоорондын лавлагааны үйлчилгээг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;

-эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний болон сонгон бүртгүүлсэн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралтын байдалд хяналт-шинжилгээ хийх, тусламж, үйлчилгээний хамралт, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

-амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй олгох эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлж хэрэгжүүлэх;



-тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг эрүүл мэндийн хэрэгцээ болон хүн амд суурилсан үйлчилгээнд үндэслэн шинэчлэх.

2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг /ТҮНШБ/ шинэчлэх талаар:

-өрх, сумын эрүүл мэндийн төвийн гүйцэтгэх үүрэг, санхүүжилтийг тодорхойлсон бодлого болон үйл ажиллагааны стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх;

-зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл болон БЗДХ, ХДХВ /ДОХ, сүрьеэтэй тэмцэх чадавхийг эрүүл мэндийн анхан шатны байгууллагын түвшинд цогц байдлаар хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

3. Үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар:

-хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн хоёрдогч шатлалын эмнэлгээс үзүүлэх тусламж, үйлчилгээг "Дүүргийн эмнэлгийн сонгодог загвар"-т нийцүүлэн өөрчлөх, гуравдагч шатлалын эмнэлгээс үзүүлэх тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх;

-бүсийн оношилгоо-эмчилгээний төвүүдийг бэхжүүлэх, шинээр байгуулах, алсын зайн оношилгоо, эмчилгээний аргыг нэвтрүүлж, оношлох чадавхийг сайжруулах;

-хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдэд ТҮНШНБ-ын дагуу чанартай нэмэлт тусламж үйлчилгээ үзүүлэх, тусламж, үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх;

-сэргээн засах тусламж, үйлчилгээний стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;

-хорт хавдраас сэргийлэх, эрт оношлох, эмчлэх чадавхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд бий болгох.

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар

-бүх шатны эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын нэгдмэл удирдлага, хяналтын механизмыг бий болгон мөрдүүлэх;

-эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох болон



эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, хамтрагч талуудыг оролцуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох талаар:

-эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор оношилгоо, эмчилгээний стандарт, шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэх;

-эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын стандарт, удирдамжийг боловсруулахад шаардагдах сургалтын материал, хөтөлбөрийг хянах, сайжруулах, шинээр боловсруулах.

Хүлээгдэж байгаа үр дүн:

-хүн ам, ялангуяа эх, хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ;

-анхан шатны, үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн болон яаралтай тусламж, үйлчилгээ сайжирна;

-эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагаа боловсронгуй болно;

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагаанд хамтрагч талуудын оролцоо нэмэгдэнэ;

-эмнэлгийн тусламж, үйлчилгээнд олон улсын стандартад нийцсэн шалгуур үзүүлэлт, эмнэл зүйн удирдамжийг мөрдөнө.

Стратегийн зорилт 3-ын хүрээнд:

1. Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах, чанартай үйлчилгээг хүргэх талаар:

-хүн амын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн тооцоолсон аргачлал боловсруулж эм ханган нийлүүлэлтэд мөрдүүлэх;



-зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг орчин үеийн эмчилгээний удирдамжтай уялдуулан шинэчлэх;

-нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлт, чохрийн шажин, сүрьеэ зэрэг төрөөс төлбөрийг нь хариуцдаг өвчний үед хэрэглэх эм, биобэлдмэлийн ханган нийлүүлэлтийг сайжруулах, түүнд хяналт тавих;

-гоц халдварт өвчин, гамшгийн үед хэрэглэх нэн шаардлагатай эм, биобэлдмэлийг хилээр саадгүй нэвтрүүлэх хууль эрх зүйн орчинг бий болгож мөрдүүлэх.

2. Хүн амд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар:

-эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар сургалт, сурталчилгааг үе шаттай явуулах;

-эмийн зохистой хэрэглээнд сөргөөр нөлөөлөх зан үйлийг өөрчлөх чиглэлээр ухуулга, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх;

-эмийн буруу хэрэглээнээс үүдэлтэй нянгийн эсрэг эмийн тэсвэртэй байдалд судалгаа хийж зөвлөмж гаргах.

3. Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодис шинжлэх лабораторийн хүчин чадлыг сайжруулах, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар зах зээлд хуурамч болон стандартын бус эм нэвтрэхээс сэргийлэх талаар:

-эм, биобэлдмэлийг шинжлэх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинжилгээний шална арга, аргачлалыг практикт нэвтрүүлэх;

-эмийн чанарын хяналтыг нэгдсэн зохицуулалттай болгон боловсронгуй болгох замаар зах зээлд хуурамч эм нэвтрэхээс сэргийлэх.

Хүлээгдэж байгаа үр дүн:

-эм ханган нийлүүлэх, хуваарилах үйл ажиллагаа оновчтой болж, хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй хангана;

-эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодисын чанарын баталгаа өгөх нэгдсэн тул олоцоо бий болж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд аюулгүй, чанарын баталгаатай, боломжит өртөгтэй эм,



биологийн нэмэлт бүтээгдэхүүн, уламжлалт эм хэрэглэнэ;

-эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэг дээшилнэ;

-салбарын хэмжээнд лабораторийн болон оношилгооны чадавхи сайжирна.

Стратегийн зорилт 4-ийн хүрээнд:

1. Хүний нөөцийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх талаар:

-эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаархи салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

-эрүүл мэндийн удирдах ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалтын жишиг хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

-бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүний нөөцийн төлөвлөлт хийх чадавхийг сайжруулах;

-эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах үйл ажиллагаанд нутгийн захиргаа, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

-эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, хүний нөөцийн чиглэлээр судалгаа, шинжилгээг өргөжүүлэх.

2. Эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчинээр хангах талаар:

-эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараахь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг олон улсын жишигт нийцүүлэх;

-эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараахь сургалт явуулдаг бааз эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх;

-эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх



зөвшөөрөл олгох шалгалт авч байгаа өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах;

-анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй оронд урт, богино хугацааны сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх;

-эмнэлгийн мэргэжилтнүүдийг англи хэл дээр мэдээлэл ашиглах, цахим эмнэлгийн орчинд ажиллах чадвархитай болгох сургалтыг зохион байгуулах;

-өндөр хөгжилтэй орнуудад анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшсэн мэргэжилтнүүдийг эх орондоо ирж өөрийн мэргэжсэн чиглэлээрээ ажиллах санал, санаачилгыг хөхиүлэн дэмжих.

3. Эмнэлгийн мэргэжилтний ажил, мэргэжлийн болон байршлын зохистой харьцааг бүрдүүлэх талаар:

-эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн баримт бичгийг хэрэгжүүлэх;

-2020 он хүртэлх эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлттэй уялдуулан төгсөлтийн өмнөх сургалтаар эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх ;рга хэмжээг хэрэгжүүлэх;

-өрх, сумын их эмч бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох;

-шаталсан сургалтын хэлбэрээр сувилагч бэлтгэх, сувилагчийн тоог нэмэгдүүлэх.

4. Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг сайжруулах талаар:

-эмнэлгийн мэргэжилтний цалин, нэмэгдэл, урамшууллыг хөдөлмөрийн бүтээмж, ажлын гүйцэтгэлтэй нь холбон боловсронгуй болгох;

-эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

5. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн байгууллага үйлчлүүлэгчээ дээдэлдэг зарчимтай



болгох талаар:

-эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зэрчимтай болгох;

-эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулах үйл ажиллагаанд олон улсын чиг хандлагыг нэвтрүүлэх;

-эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлийн мэдээллийн нэгдсэн сантай болж, сан бүрдүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах;

-эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг сайжруулахад олон нийт, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх.

6. Салбарын хэмжээний хандлага (SWAp)-д тулгуурлан эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлэх талаар:

-салбарын хөгжлийн урт хугацааны стратеги, бодлогын дагуу олон улсын байгууллага, хандивлагчдын санхүүгийн болон техникийн туслалцааг үр ашигтай зарцуулахад чиглэсэн хамтын хариуцлага бүхий зохицуулалтын механизмыг нэвтрүүлэх;

-салбар дундын хамтын ажиллагааны механизмыг сайжруулах арга замыг тодорхойлж, үр дүнг дээшлүүлэх;

-байгууллагын хөгжлийг дэмжих замаар эрүүл мэндийн ажилтнуудын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх.

7. Салбарын хэмжээнд төвлөрлийг сааруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар:

-эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар нийгмийн эрүүл мэндэд түшиглэсэн эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэх;

-хариуцлага, бие даасан болон ил тод байдал, эрх мэдлийн зохистой шилжүүлэлтийг хангах, төвлөрлийг сааруулах ажиллагааны удирдамж, зааврыг бүсчилсэн хөгжлийн болон засаг захиргааны шинэчлэлтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх;

-төвлөрлийг сааруулах замаар нутгийн захиргаа болон эрүүл мэндийн удирдах ажилтны чадавхийг системтэйгээр бэхжүүлэх;

-эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх.



хянаж-үнэлэхэд олон нийт, ТББ, орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх.

8. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх талаар:

-байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, орчны бохирдол, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын үед авах арга хэмжээ, бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтныг эрсдэлийн үнэлгээ хийх талаар сургалтад хамруулах.

9. Эрүүл мэндийн салбарт төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх талаар:

-эрүүл мэндийн салбарын хувийн хэвшлийн хөгжлийн өнөөгийн байдлыг үнэлэх, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг эрүүл мэндийн болон эрүүл мэндийн санхүүжилтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх;

-эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн нэвтрүүлж байгаа шинэ техник, технологийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг үйлчлүүлэгчдэд ээлтэй, санхүүгийн дарамт үүсгэхгүй хэлбэрээр хэрэглэх эрх зүйн орчинг судлан боловсруулж, хэрэгжүүлэх;

-хувийн хэвшлийг хөгжүүлэх санхүүгийн механизмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, үр ашгийг дэмжих хөшүүрэг болгон боловсронгуй болгох.

Хүлээгдэж байгаа үр дүн:

-эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагын нэгдмэл тогтолцоо бэхжинэ;

-эмнэлгийн мэргэжилтний зохистой харьцаа бүрдэнэ;



-өндөр мэдлэг, ур чадвар бүхий нийгмийн баталгаа нь хангагдсан, ёс зүйтэй эмнэлгийн мэргэжилтнээр эрүүл мэндийн салбар хангагдана;

-эрүүл мэндийн байгууллагын бүх түвшинд удирдлагын чадавхи бэхжинэ;

-байгалийн гамшгийн үед бэлэн байх цогц төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлснээр эрсдэлийн менежментийн чадавхи сайжирна;

-салбарын менежмент нь хариуцлагатай, ил тод, төвлөрөл саарсан тогтолцоонд шилжиж, үйл ажиллагаа нь жигдэрнэ;

-хамтрагч болон оролцогч талуудын хамтын ажиллагаа сайжирна;

-эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үр дүнтэй зохицуулалт бий болно.

Стратегийн зорилт 5-ын хүрээнд:

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар:

-ДНБ-д эзлэх эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хувь, хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх;

-эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтэд эрүүл мэндийн даатгалын эзлэх хувийг нэмэгдүүлэх;

-эрүүл мэндийн нийт зардалд үйлчлүүлэгчийн өөрөө төлөх төлбөрийн хэмжээг 25 хувиас хэтрүүлэхгүй байх.

2. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон бусад нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах талаар:

-эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэг удирдлага дор нэгдмэл бодлогоор худалдан авах тогтолцоог төлөвшүүлж зардлын үр ашгийг нэмэгдүүлэх;



-нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлыг бууруулах;

-эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр гадаад болон дотоод эх үүсвэрийг дайчлах;

-эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлал хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, орны тоог багасгах, эмнэлэгт хэвтэх хугацааг бодитой тогтоох зэргээр зардлын үр ашгийг нэмэгдүүлэх;

-гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг эрүүл мэндийн талаархи төрөөс баримтлах бодлого, зарчимтай уялдуулж, үр ашгийг дээшлүүлэх.

3. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бие даалган хөгжүүлэх талаар:

-эрүүл мэндийн даатгалын бүх нийтийг хамарсан, заавал даатгуулах хэлбэрийг дэмжих;

-эрүүл мэндийн даатгалын асуудлыг хариуцсан бие даасан байгууллага байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-хүн амын эрүүл мэндэд гарч болох гэнэтийн, нийтийг хамарсан өвчлөлийн улмаас үүсэх санхүүгийн томоохон хэмжээний дарамтаас хамгаалах механизмыг бий болгон хэрэгжүүлэх;

-улсын төсвөөс төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг инфляци, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодит өртөгтэй уялдуулан нэмэгдүүлэх.

Хүлээгдэж байгаа үр дүн:

-ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардлын хувь тогтвортой байна;

-тусламж, үйлчилгээний шатлал бүрт тохирсон, үр дүнд тулгуурласан, чанарыг дэмжсэн, сөрөг хөшүүргийг зохицуулахад анхаарсан



төлбөрийн оновчтой арга, хэлбэр нэвтэрнэ;

-эрүүл мэндийн санхүүжилтийн бодлого хэрэгжинэ;

-эрүүл мэндийн үндэсний тооцоо (олон улсын стандарт)-нд түшиглэсэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн удирдлагын мэдээллийн тогтолцоо бий болж, салбарын хэмжээнд хэрэгжинэ;

-анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хуваарилагдах санхүүжилт нэмэгдэнэ;

-хүн ам, ялангуяа эмзэг бүлгийнхний эрүүл мэндийн даатгалд хамрагдах хувь нэмэгдэнэ;

-эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа сайжирна.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан 2021 он хүртэл хоёр үе шаттай хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2010-2015 он

Хоёрдугаар үе шат: 2016-2021 он

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

-улсын болон орон нутгийн төсөв;

-хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө;

-бусад эх үүсвэр.



**Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

-Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

-Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга нар аймаг, нийслэлийн нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТҮНШБ	Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багц
ТҮНШНБ	Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай нэмэлт багц
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МСС	Мэдээлэл, сургалт сурталчилгаа
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
SWAp	Салбарын хэмжээний хандлага
ЭМУМНТ	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн нэгдмэл тогтолцоо
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдлын вирус /Дархлалын олдмол хомсдол

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medecle@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн зураг 2.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тогмлын тэдэрин дээдэлэ хэсэгт хэвлэл.
Утас 329487